

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/01-НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Утас: 7036-3040 Аудитын менежер: Утас: 7036-3036	Ч.Энхтуяа Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Б.Батмөнх Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2024 он	Ахлах аудитор: Утас: 7036-2442	Т.Болор Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-30
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	25
4. Аудитын тайлан	31
4.1 Ерөнхий зүйл	31
4.2 Материаллаг байдал	31
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	31
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	32
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	33
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	34
5. Аудитын илрүүлэлт	35-40
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	41-42

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНСАХЗ	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭС	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ШХА	Шууд худалдан авалт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2024.04.19 № СЭА-2024/01-НА-СТА-ТЭЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 108,615.6 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 91,612.1 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 84.3 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 15.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Өмнөх онд ААНОАТ-ын орлогын төлөвлөгөө тасарснаас шалтгаалан 2023 оны орлогоос тооцон 9,165.4 сая төгрөгийг улсын төсвөөс аймгийн төсөвт урьдчилан төвлөрүүлснийг тайлант онд суутган тооцуулсан байна.

018020445⁴

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын 2024 оны 153, 154 дүгээр тогтоолуудаар “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2023 онд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг “Тодорхой үр дүнд хүрсэн”, “Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 94.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж тус тус үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,714,023.5	51,453,353.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,315,692.6	22,955,709.8
33	АВЛАГА	15,806,140.6	15,447,245.2
34	УРЬДЧИЛГАА	3,162,026.5	2,177,544.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8,407,275.4	10,866,182.4
36	НӨӨЦИЙН БАРАА	22,888.4	6,671.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	157,554,594.9	159,631,171.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,554,594.9	159,631,171.5
39200	Биет хөрөнгө	145,184,999.8	147,213,332.7
39300	Биет бус хөрөнгө	12,369,595.1	12,417,838.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	216,268,618.3	211,084,525.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,951,478.6	18,203,171.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,624,882.3	18,030,129.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	373,180.9	373,180.9
41300	Өглөг	16,030,095.2	17,614,910.9
41400	Урьдчилж орсон орлого	9,221,606.3	42,037.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	326,596.2	173,042.6
42200	Урт хугацаат зээл	326,596.2	173,042.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	190,317,139.8	192,881,353.5
51	Засгийн газрын хувь оролцоо	190,317,139.8	192,881,353.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	39,751,439.9	41,162,311.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	5,080,488.6	5,080,488.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	17,292,426.8	17,968,582.6
51200	Хуримтлагдсан үр дүн	68,671,075.4	83,301,242.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,521,709.1	45,368,728.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	216,268,618.3	211,084,525.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН -I	88,109,533.2	135,142,852.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	47,681,029.4	64,809,717.2
110	Орлогын албан татвар	27,970,043.6	49,776,377.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	23,129,870.0	30,398,192.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,402,447.0	-1,671,857.1
1103	ААН-ын орлогын албан татвар	6,242,620.6	21,050,042.1
113	Хөрөнгийн албан татвар	5,610,827.9	4,726,870.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,100,157.8	10,306,468.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,013,433.6	50,975,773.9
120	Нийтлэг татварын бус орлого	15,772,135.8	30,603,224.0
121	Хөрөнгийн орлого	97,564.7	171,998.7
122	Тусламжийн орлого	24,200.0	30,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	12,119,533.0	20,170,551.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,415,070.3	19,357,361.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	61,897,077.2	81,897,172.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,637,931.6	75,385,120.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,851,976.5	69,058,908.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,881,652.8	15,792,603.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,450,625.3	1,968,180.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,946,807.1	2,398,926.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,363,713.6	1,637,468.0
2105	Нормативт зардал	89,399.1	28,208.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,587,907.0	1,260,724.6
2107	Томилолт, зочны зардал	244,455.5	366,740.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,313,189.2	22,987,672.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,974,226.9	22,618,384.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,785,955.1	6,326,211.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,259,145.6	6,512,051.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН -III=-I--II	26,212,456.1	53,245,680.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	10,714.1	480.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	174,185,014.0	38,205,812.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН -VI=-III+-IV--V	-147,961,843.9	15,040,348.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	342,264,307.2	0.0	342,264,307.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,996,459.8	0.0	-8,996,459.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	333,267,847.5	0.0	333,267,847.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,672.0	0.0	45,672.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	4,976,107.2	0.0	4,976,107.2
8	Зарласан ногдол ашиг	-10,643.0	0.0	-10,643.0
9	Тайлант үеийн үр дүн	-147,961,843.9	0.0	-147,961,843.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,317,139.8	0.0	190,317,139.8
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,317,139.8	0.0	190,317,139.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-410,180.6	0.0	-410,180.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,906,959.1	0.0	189,906,959.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-5,165,137.1	0.0	-5,165,137.1
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-2,195,274.2	0.0	-2,195,274.2
17	Өмчид гарсан өөрчлөлт	2,012,567.6	0.0	2,012,567.6
19	Тайлант үеийн үр дүн	8,322,238.1	0.0	8,322,238.1
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,881,353.5	0.0	192,881,353.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	102,235,812.5	118,422,179.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	56,846,430.4	55,659,840.6
110	Орлогын албан татвар	37,135,444.7	40,610,976.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	23,129,870.0	30,398,192.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,402,447.0	-1,671,857.1
1103	ААН-ын орлогын албан татвар	15,408,021.7	11,884,641.0
113	Хөрөнгийн албан татвар	5,610,827.9	4,742,673.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	14,100,157.8	10,306,191.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,067,321.5	2,130,154.9
1181	Газрын төлбөр	2,473,886.2	2,891,486.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,558,950.1	5,284,549.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,022,979.8	44,092,954.3
120	Нийтлэг татварын бус орлого	20,781,682.0	23,720,404.4
121	Хөрөнгийн орлого	97,564.7	171,998.7
122	Тусламжийн орлого	24,200.0	30,000.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	12,119,533.0	20,170,551.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,366,402.3	18,669,385.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,107,379.6	78,146,077.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,107,379.6	78,146,077.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,115,689.1	71,821,290.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,769,804.4	22,197,350.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,202,055.9	2,934,150.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,746,176.4	4,688,996.7
2104	Хангамж, бараа материалын зардал	7,137,250.5	8,816,014.2
2105	Нормативт зардал	55,927.0	29,107.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,690,636.7	942,406.6
2107	Томилолт, зочны зардал	255,186.5	364,226.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,490,061.3	19,491,384.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,768,590.4	12,357,654.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,991,690.5	6,324,787.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	37,128,432.9	40,276,102.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	171,936.1	1,300,884.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	33,293,642.5	48,021,238.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,293,642.5	48,021,238.0
2200	Дотоод эх үүсвэрээр	33,293,642.5	48,021,238.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-33,121,706.4	-46,720,353.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,215,428.6	-1,915,731.6
14	Бусад эх үүсвэр	300,000.0	33,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	768,278.0	1,762,178.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	747,150.6	186,553.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,791,297.9	-8,359,982.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,524,394.7	31,315,692.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,315,692.6	22,955,709.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,615,559.4	91,612,124.1	-17,003,435.3	84.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,447,252.0	56,476,985.7	-3,970,266.3	93.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,035,944.5	50,513,268.2	-3,522,676.3	93.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,467,387.8	15,761,922.1	-705,465.7	95.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,115,431.0	1,969,132.6	-146,298.4	93.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,576,990.8	15,634,924.2	-942,066.6	94.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,462,754.6	1,349,452.7	-113,301.9	92.3
2105	Нормативт зардал	23,130.0	12,233.1	-10,896.9	52.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,119,064.9	2,965,661.9	-153,403.0	95.1
2107	Томилолт, зочны зардал	386,480.8	354,962.6	-31,518.2	91.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,153,667.5	4,616,475.3	-537,192.2	89.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,731,037.1	7,848,503.7	-882,533.4	89.9
212	ТАТААС	131,405.0	131,405.0	0.0	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	131,405.0	131,405.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,279,902.5	5,832,312.5	-447,590.0	92.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,483,407.9	5,190,585.9	-292,822.0	94.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	796,494.6	641,726.6	-154,768.0	80.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,271,165.2	33,372,960.4	-11,898,204.8	73.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,897,142.2	1,762,178.0	-1,134,964.2	60.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,615,559.4	91,678,605.5	-16,936,953.9	84.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,120,135.7	89,762,016.6	9,641,880.9	112.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,098,366.0	1,886,588.9	-22,211,777.1	7.8
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,397,057.7	30,000.0	-4,367,057.7	0.7
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	5,855,825.5	5,855,825.5	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,922,306.9	5,922,306.9	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1685	1649	-36	97.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	49	49	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	818	800	-18	97.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,774,356.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,970,124.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,859,415.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,298.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,547.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,213.8
2104	Хангамж, бараа материалын зардал	86,577.7
2105	Нормативт зардал	16,873.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	283,406.5
2107	Томилолт, зочны зардал	9,263.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,073.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,334,158.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,709.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	492,474.6
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	618,234.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	804,231.9
2200	Дотоод эх үүсвэрээр	804,231.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,774,356.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,774,356.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч /цаашид Аймгийн ТЕЗ гэх/ нь “Хүнээ дээдэлж, хамтдаа хөгжье” гэсэн эрхэм зорилгын хүрээнд 2023 оныг “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” болгон үйл ажиллагаа явуулсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд аймгийн Засаг даргын бүрэн эрхийг дараах байдлаар тусгасныг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах;
- Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Аймгийн төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;
- Аймгийн өмчийн эзэмшил, ашиглалтыг зохион байгуулж, бусдад эзэмшүүлэх, түрээслэх, худалдах, хувьчлах зэрэг асуудлаар захиран зарцуулах санал боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлэх;
- Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах;
- Гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд буюу түүний тодорхой хэсэгт түр хугацаанд дагаж мөрдөх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, хүн хүч дайчлах, төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэр, холбооны хэрэгсэл, хүнс тэжээлийн нөөцийг дайчлах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 82 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсөв баталсан,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар “Сэлэнгэ аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийсэн,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 141 дүгээр “Сэлэнгэ аймгийн 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийсэн гэх мэт.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тус чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2023 онд орон нутгийн төсвөөс 170.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд аудитын явцад тус газрын тайлант онд хийж гүйцэтгэсэн ажлыг холбогдох баримт, материалын хүрээнд тулган баталгаажуулахад 36 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж гүйцэтгэн дараах алдаа, зөрчлийг илрүүлж, шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 1 байгууллагын 5.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага,
- 36 байгууллагын 110.6 сая төгрөгийн зөрчилд 111 зөвлөмж.

Дээрх байдлаас дүгнэхэд аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь бүтэн жилийн хугацаанд хийсэн хяналт шалгалт, дотоод аудитаар нийт 116.0 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн нь төсвөөс авсан 1.0 төгрөгийн санхүүжилт тутамд 0.7 төгрөгийн зөрчил илрүүлсэн буюу хяналт шалгалтын үр нөлөө, үр ашиг туйлын хангалтгүй болохыг харуулж байна.

Дотоод хяналт шалгалт, аудитын үр нөлөө хангалтгүй байгаа нь хяналт шалгалт, аудитыг эрсдэлд суурилан гүйцэтгэдэггүй, ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгийн эргэлт явагддаг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, ОНӨААТҮГ болон төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагчдын тухайн жилийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг дотоод аудитад хамруулдаггүй, илрүүлсэн зөрчлийг барагдуулах арга хэмжээ авдаггүй зэргээс шалтгаалж байна гэж дүгнэж байна.

Энэ мэтчилэн аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын үр нөлөө хангалтгүй байгаагаас Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хийж гүйцэтгэж буй санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил жил бүр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11,928.5 сая төгрөгийн /ТЕЗ-ийн санхүүгийн тайланд залруулсан 121,263.3 сая төгрөгийн залруулсан алдааг хассан дүн/ алдаа, зөрчил илрүүлж, дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 7,042.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан,
- 75.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож,
- 3,445.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага,
- 1,365.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Бид аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн ТЕЗ-ийн харьяаны төсөвт байгууллагууд, сумдын төрийн сан, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Дээрх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,184.1 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	31,315.7	22,955.7	-8,360.0
Авлага	15,806.1	15,447.2	-358.9
Урьдчилгаа	3,162.0	2,177.5	-984.5
Бараа материал	8,407.3	10,866.2	2,458.9
Нөөцийн бараа	22.9	6.7	-16.2
Үндсэн хөрөнгө	157,554.6	159,631.2	2,076.6
Нийт хөрөнгө	216,268.6	211,084.5	-5,184.1
Өр төлбөр	25,951.5	18,203.2	-7,748.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	190,317.1	192,881.3	2,564.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	216,268.6	211,084.5	-5,184.1

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 22,955.7 сая төгрөг болж, өмнөх оноос 8,360.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	7.8	18.2	10.4
Банканд байгаа бэлэн мөнгө	31,307.9	22,937.5	-8,370.4
Төрийн сангийн харилцах	29,537.1	19,893.7	-9,643.4
Арилжааны банк дахь харилцах	1,770.8	3,043.8	1,273.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.0	0.0	0.0
Нэмэлт санхүүжилтийн арилжааны	0.0	0.0	0.0

банк			
Дүн	31,315.7	22,955.7	-8,360.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 22,955.7 сая төгрөг нь дараах байдлаар байршиж байна. Үүнд:

- Орон нутгийн өмчит 9 үйлдвэрийн газрын касс 18.2 сая төгрөг,
- Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 36.3 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 3,015.5 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 1,376.8 сая төгрөг,
- 17 сумын ТТЗ болон түүний харьяа байгууллагуудын харилцах дансанд 15,465.1 сая төгрөг,
- Орон нутгийн өмчит 22 үйлдвэрийн газрын арилжааны банкин дахь харилцах дансанд 3,043.8 сая төгрөг гэх мэт.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 22,955.7 сая төгрөгийн 25.8 хувийг төсөвт байгууллага, 14.9 хувийг төсөл, сан, 46.0 хувийг төрийн сан, 13.3 хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл тус тус эзэлж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 15,447.2 сая төгрөг болж, өмнөх оноос 358.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	46.7	21.4	-25.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	0.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	222.4	245.9	23.5
Дансны авлага /ОНӨААТҮГ/	5,907.7	5,158.9	-748.8
Татвар, НДШ-ийн авлага /ОНӨААТҮГ/	7.4	6.6	-0.8
Бусад авлага	5,168.8	5,025.5	-143.3
Зээлийн авлага	4,453.1	4,988.9	535.8
Дүн	15,806.1	15,447.2	-358.9
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	4,723.5	5,160.0	436.5
Төсөл/ сан	99.0	200.2	101.2
Төрийн сан	318.8	317.9	-0.9
ОНӨААТҮГ	10,664.8	9,769.1	-895.7
Дүн	15,806.1	15,447.2	-358.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 9,401.8 сая төгрөг буюу 60.9 хувийг дараах ОНӨААТҮГ-ын авлагууд эзэлж байна. Үүнд:

- “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ 4,390.3 сая төгрөг буюу 46.7 хувь, /хуваарийн дагуу төлөх орон сууцны төлбөр/
- “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ 1,856.7 сая төгрөг буюу 19.8 хувь,
- “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ 1,459.6 сая төгрөг буюу 15.5 хувь,
- “Гавшгай ус” ОНӨААТҮГ 1,695.2 сая төгрөг буюу 18.0 хувийг гэх мэт.

Авлагын үлдэгдлийн 79.9 хувийг 12,348.9 сая төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай авлага эзэлж байна. Үүнд:

- Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын байгууллагаас авах 4,370.4 сая төгрөг,
- ОНӨААТҮГ-ын дансны авлага 4,494.7 сая төгрөг,
- Хоршоог хөгжүүлэх сан / ХХС /-аас олгосон зээлийн 2,859.2 сая төгрөгийн, зээлийн хүүгийн 162.1 сая төгрөг,
- Хувь хүмүүсээс авах авлага 462.5 сая төгрөг гэх мэт.

Дээрх олон жилийн насжилттай авлагуудын зарим эзэн холбогдогч нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхой бус байдлаас болж шүүхэд хандах боломжгүй, зарим авлагын хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон байна.

ХХС-ийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулснаар эргэн төлөлт харьцангуй нэмэгдэж байгаа ч хугацаа хэтэрсэн үлдэгдэл их байгаа нь сангийн эх үүсвэр бүрдэхгүй байх, эргэц удаашрах, төсвийн хөрөнгө үрэгдэх эрсдэл, үр дагаврыг бий болгож байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Сант сумын ЗДТГ 4.2 сая төгрөг, Сүхбаатар сумын Засаг дарга 13.9 сая төгрөг, Хүдэр сумын ИТХ 2.5 сая төгрөг, Хүдэр сумын ЗДТГ 1.8 сая төгрөг зэрэг нийт 8 байгууллага **23.7 сая төгрөгийн авлага үүсгэсэн.** /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2,177.5 сая төгрөг болж, өмнөх оноос 984.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,162.0	2,177.5	-984.5
Дүн	3,162.0	2,177.5	-984.5
Үүнээс байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	3,135.9	2,163.8	-972.1
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ОНӨААТҮГ	26.1	13.7	-12.4
Дүн	3,162.0	2,177.5	-984.5

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 180.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, УТХО-аар хэрэгжүүлэх 1,903.4 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар хүлээн авч, санхүүжилтийг гүйцэтгэгчид олгон, урьдчилгаа данснаас хасаж бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд байгаа УТХО-ын 1,809.0 сая төгрөг, ОНХС-ийн 215.6 сая төгрөг, ОНХО-ын 139.2 сая төгрөгийн бүрэн хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг Засгийн газрын 2023

оны 466 дугаар тогтоол болон аймгийн Засаг даргын 2023 оны А/659 дүгээр захирамжаар барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, урьдчилж гарсан зардлаар тайлагнасан байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 10,866.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2,458.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	439.2	477.9	38.7
Эм боох материал	2.9	2.9	0.0
Дуусаагүй үйлдвэрлэл	0.0	0.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	70.1	78.4	8.3
Бичиг хэргийн материал	117.7	125.1	7.4
Аж ахуйн материал	1,270.7	1,687.5	416.8
Сэлбэг хэрэгсэл	879.0	930.3	51.3
Түлш, шатах тослох материал	11.6	27.3	15.7
Барилгын засварын материал	164.9	1,090.4	925.5
Хүнсний материал	1.5	4.1	2.6
Бусад хангамжийн материал	5,290.9	6,178.7	887.8
Биологийн хөрөнгө	7.0	7.0	0.0
Мал амьтад	151.8	256.6	104.8
Дүн	8,407.3	10,866.2	2,458.9
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	6,483.0	8,434.0	1,951.0
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ОНӨААТҮГ	1,924.3	2,432.2	507.9
Дүн	8,407.3	10,866.2	2,458.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2,458.9 сая төгрөгөөр өсөхөд дараах ажил гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 32,027.2 сая төгрөгийн бараа материал худалдан авсан,
- 1,922.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан болон
- 10,351.0 сая төгрөгийн бараа материал зарцуулсан,
- 19,927.0 сая төгрөгийн бараа материал шилжүүлсэн,
- 1,212.3 сая төгрөгийн бараа материалыг акталсан гэх мэт.

Бусад хангамжийн материалын үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 901.2 сая төгрөгийн дуусаагүй төсөл, арга хэмжээнүүдийг хуримтлуулан бүртгэсэн байна. Үүнд:

- Мандал сумын Ахмадын төвийн барилга 400 сая төгрөг,
- Сүхбаатар сумын Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилгын 500 сая төгрөг,
- Залуучуудын хөгжлийн ордны барилгын 1.2 сая төгрөг,

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 6.7 сая төгрөг болж, өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нөөцийн барааны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тэжээлийн нөөц	19.1		-19.1
Бусад нөөц	3.8	6.7	2.9
Дүн	22.9	6.7	-16.2

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансны үлдэгдэл буурсан нь өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор Жавхлант сумын тэжээлийн нөөцөөс 19.1 сая төгрөгийн 3187 боодол өвсийг зарцуулсан, Сүхбаатар сумын орон сууцны дулааны тогтвортой байдлыг хангах, тохиолдох гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь нүүрсний нөөцийг 2.9 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 159,631.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2,076.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	145,185.0	147,213.4	2,028.4
Барилга, байгууламж, орон сууц	85,753.7	78,290.9	-7,462.8
Хуримтлагдсан элэгдэл	-12,259.0	-11,817.6	441.4
Авто тээврийн хэрэгсэл	7,847.6	10,094.8	2,247.2
Хуримтлагдсан элэгдэл	-4,082.2	-4,755.4	-673.2
Машин тоног төхөөрөмж	11,120.0	12,110.3	990.3
Хуримтлагдсан элэгдэл	-5,513.7	-6,074.3	-560.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,167.6	2,590.5	422.9
Хуримтлагдсан элэгдэл	-1,271.3	-1,490.9	-219.6
Зам, гүүрний байгууламж	40,258.1	46,265.6	6,007.5
Хуримтлагдсан элэгдэл	-7,071.1	-13,020.5	-5,949.4
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	73.7	14.3	-59.4
Бусад үндсэн хөрөнгө	36,144.7	39,479.7	3,335.0
Хуримтлагдсан элэгдэл	-11,209.9	-13,073.4	-1,863.5
Дуусаагүй барилга, байгууламж	3,100.8	8,473.5	5,372.7
Ном	126.0	125.9	-0.1
Биет бус хөрөнгө	12,369.6	12,417.8	48.2
Программ хангамж	187.2	253.5	66.3
Хуримтлагдсан элэгдэл	-66.8	-138.0	-71.2
Бусад биет бус хөрөнгө	12,348.0	12,345.3	-2.7
Хуримтлагдсан элэгдэл	-98.8	-43.0	55.8
Дүн	157,554.6	159,631.2	2,076.6

/сая төгрөгөөр/

Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	65,869.5	86,291.1	20,421.6
Төсөл/ сан	2.6	1.9	-0.7
Төрийн сан	0.0	0.0	0.0
ОНӨААТҮГ	91,682.5	73,338.2	-18,344.3
Дүн	157,554.6	159,631.2	2,076.6

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 2,076.6 сая төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,643.7 сая төгрөг,
- Балансаас баланст шилжүүлэн авсан 20,885.4 сая төгрөг,
- Хандиваар болон бусад 8,434.6 сая төгрөг,
- Дахин үнэлгээний нэмэгдэл 9,758.6 сая төгрөг зэрэг нийт 44,722.3 сая төгрөгөөр нэмэгдэж,
- Балансаас баланст шилжүүлсэн 5,653.5 сая төгрөг,
- Акталсан болон бусад 15,313.3 сая төгрөг
- Дахин үнэлгээний хорогдол 12,968.9 сая төгрөг зэрэг нийт 33,935.7 сая төгрөгийн бууралтаас.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 18,203.2 сая төгрөг болж, өмнөх оноос 7,748.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	25,624.9	18,030.2	-7,594.7
Богино хугацаат зээлийн өглөг	373.2	373.2	
Арилжааны банк	373.2	373.2	
Өглөг	3,834.5	3,322.8	-511.7
Ажилчидтай холбогдсон өглөг	134.9	192.0	57.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	78.7	35.2	-43.5
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	3,563.9	3,052.3	-511.6
Зээлийн хүүгийн өглөг	57.0	43.3	-13.7
Бусад өглөг	12,195.6	14,292.2	2,096.6
Байгууллагад төлөх өглөг	897.9	808.4	-89.5
Хувь хүмүүст төлөх өглөг	10.0	11.8	1.8
Татварын өглөг /ОНӨААТҮГ/	3,988.7	5,061.0	1,072.3
НДШ-ийн өглөг /ОНӨААТҮГ/	3,577.9	4,342.6	764.7
Ноогдол ашгийн өглөг /ОНӨААТҮГ/	2.0	2.0	
Дансны өглөг /ОНӨААТҮГ/	3,719.1	4,066.4	347.3
Урьдчилж орсон орлого	9,221.6	42.0	-9,179.6
Урт хугацаат өр төлбөр дүн	326.6	173.0	-153.6
Арилжааны банк	265.3	161.7	-103.6
Бусад урт хугацаат өр төлбөр /ОНӨААТҮГ/	61.3	11.3	-50.0
Дүн	25,951.5	18,203.2	-7,748.3
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	4,077.6	3,489.1	-588.5

Төсөл, сан	317.1	260.5	-56.6
Төрийн сан	9,169.1	7.7	-9,161.4
ОНӨААТҮГ	12,387.7	14,445.9	2,058.2
Дүн	25,951.5	18,203.2	-7,748.3

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 7,748.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд Сангийн яамнаас хуваарилсан 9,165.4 сая төгрөгийн урьдчилгааг тайлант онд ААНОАТ-аар бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

Нийт өр төлбөрийн 50.5 хувийг буюу 9,187.9 сая төгрөгийг “Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын, 16.8 хувь буюу 3,052.3 сая төгрөгийг УТХО, ОНХС, ОНХО-ын барьцаа хөрөнгийн, 11.1 хувь буюу 2,028.5 сая төгрөгийг “Гавшгай ус” ААТҮГ-ын, 10.8 хувь буюу 1,968.5 сая төгрөгийг “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын өглөгүүд тус тус эзэлж байна.

Урт хугацаат зээлийн өр төлбөр дансны оны эцсийн үлдэгдэл 173.0 сая төгрөгийн 93.5 хувь буюу 161.7 сая төгрөг нь “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын арилжааны банкнаас авсан зээлийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас Ерөө сумын ИТХ 4.5 сая төгрөг, Орхон сумын ЗДТГ 2.7 сая төгрөг, Сайхан сумын ОНХС 4.2 сая төгрөг зэрэг нийт 7 байгууллага 12.8 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./
- Шаамар сумын ЗДТГ 0.4 сая төгрөг, Мандал сумын ЗДТГ 13.2 сая төгрөг зэрэг нийт 13.6 сая төгрөгийн өмнөх оны санхүүгийн тайланд тусгаагаагүй өр төлбөрийг тайлант оны төсвөөс төлж барагдуулсан.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 192,881.3 сая төгрөг болж, өмнөх оноос 2,564.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,751.4	40,970.5	1,219.1
Өмч /төрийн/ /ОНӨААТҮГ/	5,080.5	5,272.3	191.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ОНӨААТҮГ/	17,292.4	17,968.6	676.2
Хуримтлагдсан үр дүн	68,671.1	83,301.2	14,630.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,521.7	45,368.7	-14,153.0
Дүн	190,317.1	192,881.3	2,564.2
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Төсөвт байгууллага	86,080.2	108,037.2	21,957.0
Төсөл, сан	231.8	342.4	110.6
Төрийн сан	10,312.8	10,325.7	12.9
ОНӨААТҮГ	93,692.3	74,176.0	-19,516.3

Дүн	190,317.1	192,881.3	2,564.2
------------	------------------	------------------	----------------

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 2,564.2 сая төгрөгөөр өсөхөд дараах өөрчлөлтүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- *Тайлант оны хуримтлагдсан үр дүн 14,630.1 сая төгрөгөөр өссөн,*
- *2018 онд хийгдсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр хөрөнгийг хэт өндөр үнэлж элэгдлийн зардал өндөр гарснаар ашиг, алдагдалд нөлөөлж байсан тул тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээг зөвхөн барилга, байгууламжид хийж, дахин үнэлгээний зөрүүг 14,152.9 сая төгрөгөөр бууруулсан. Үүнд:*
 - ✓ *“Цэнгээ ус” ОНӨААТҮГ нь 5,165.1 сая төгрөг,*
 - ✓ *“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь 6,718.1 сая төгрөг,*
 - ✓ *“Гавшгай ус” ОНӨААТҮГ нь 2,269.7 сая төгрөг,*

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 7 ОНӨААТҮГ, 6 ТТЗ-ийн нийт 13 байгууллагын өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 410.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн байна. Үүнд:

Хүснэгт 10. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн
1	Гавшгай ус			-0.7
2	Сэлэнгэ-Энерго			-581.4
3	Тохилог Хараа ААТҮГ			21.8
4	Мандах Зэлтэр ОНӨҮГ			12.9
5	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ			-26.8
6	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ			78.0
7	Сэлэнгэ орон сууц			72.9
8	Ерөө сумын ХХС			-1.7
9	Зүүнбүрэн сумын ХХС			2.3
10	Мандал сумын ХХС			-9.2
11	Орхон сумын ХХС			-3.0
12	Сант сумын ЗДТГ			0.2
13	Цагааннуур спорт цогцолбор			24.5
	НИЙТ			-410.2

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой материаллаг хэмжээний залруулгыг тодруулбал:

- *“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь татварын болон ажиллагсадтай холтоотой өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, хуримтлагдсан үр дүнг 581.4 сая төгрөгөөр бууруулсан,*
- *“Цагаан Эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь үндсэн хөрөнгө, элэгдэлтэй холбоотой хуримтлагдсан үр дүнг 78.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,*
- *“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь төрийн албан хаагчдаас авах орон сууцны зээлийн авлага, аймаг хөгжүүлэх сангийн хүмүүсээс авлагын зөрүүгээс үүссэн 72.9 сая төгрөгийг залруулан, хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэн,*

- Цагааннуур сумын Спорт цогцолборын 24.5 сая төгрөгийн өглөгийг БТСГ-аас барагдуулсан тул хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэн гэх мэт.

3.4.9 Орлогын данс

Аймаг, сумдын 2023 оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 54,942.0 сая төгрөг, татварын бус орлогыг 9,167.4 сая төгрөг зэрэг нийт **64,109.4** сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **69,659.6** сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 5,550.2 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 11. Аймаг, сумдын төсвийн орлого

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Аймаг		Сумд		Нийт орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	19,440.0	25,065.1	35,502.0	39,759.9	54,942.0	64,825.0	9,883.0	118.0
ХХОАТ		313.5	26,619.6	30,084.7	26,619.6	30,398.2	3,778.6	114.2
ХХОАТ-ын буцаалт			(1,661.2)	(1,671.8)	(1,661.2)	(1,671.8)	(10.6)	100.6
ААНОАТ	17,400.0	21,050.0			17,400.0	21,050.0	3,650.0	121.0
Хөрөнгийн албан татвар	740.0	1,072.8	4,399.3	3,669.8	5,139.3	4,742.6	(396.7)	92.3
Бусад татвар, төлбөр, хураамж	1,300.0	2,628.8	6,144.3	7,677.2	7,444.3	10,306.0	2,861.7	138.4
Татварын бус орлого	5,410.2	1,185.3	3,757.2	3,649.3	9,167.4	4,834.6	(4,332.8)	52.7
Хүү, торгуулийн орлого	750.0	388.5	1,580.8	2,179.1	2,330.8	2,567.6	236.8	110.2
Нэр заагдаж ангилагдаагүй орлого	1,925.0	594.9	640.3	1,470.2	2,565.3	2,065.1	(500.2)	80.5
Хөрөнгийн орлого		171.9				171.9	171.9	
Хандив, тусламжийн орлого	2,735.2	30.0	1,536.1		4,271.3	30.0	(4,241.3)	0.7
Нийт орлого	24,850.2	26,250.4	39,259.2	43,409.2	64,109.4	69,659.6	5,550.2	108.7

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлого:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Мандал, Ерөө, Баянгол, Хүдэр, Сайхан, Цагааннуур, Хушаат зэрэг сумдын орлого 2,783.6 сая төгрөгөөр,
- **Ус, рашаан ашигласны төлбөр:** Бороо гоулд, Болд төмөр ерөө гол, Ди Зэт энд Ай, Тод ундарга, Чамин алт зэрэг томоохон компаниуд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөрийн өмнөх оны өрийг төлж барагдуулсантай холбоотойгоор 1,163.9 сая төгрөгөөр,

- **Газрын дуудлага худалдаа:** Цагааннуур, Сайхан, Орхонтуул, Түшиг, Баянгол, Сант зэрэг сумдын газрын дуудлага худалдааны орлого нийт 933.0 сая төгрөгөөр,
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал, ашигласны төлбөр:** “Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл 2 хэсэг” тайлант онд Түшиг, Цагааннуур сумын нутагт авто замын ажил явагдаж, замын хучилт, далангийн ажилд хэрэглэгдэх хайрга ашигласны төлбөр 567.5 сая төгрөгөөр,
- **Үйл ажиллагааны орлогын албан татвар:** Сүхбаатар, Мандал, Орхон, Сайхан зэрэг сумдын хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаа өргөжсөнтэй холбоотойгоор тус орлого 573.8 сая төгрөгөөр,
- **Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Ерөө, Мандал, Түшиг, Хүдэр зэрэг сумдын ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлээний мод бэлтгэх зөвшөөрлийн мод бэлтгэх эрхийн бичгийн орлого, БОЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Ойн ангитай хамтран самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар ААН-үүдтэй нэмж гэрээ байгуулж, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого нэмэгдэж нийт 282.0 сая төгрөгөөр,
- **Нэр заагаагүй бусад орлого:** Хуш модны самар бэлтгэх журамд өөрчлөлт орж үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нөөцийн нэмэлт зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгож, дэнчингийн орлого төвлөрснөөс шалтгаалан Хүдэр, Мандал, Ерөө сумдын орлого нийт 895.1 сая төгрөгөөр,
- **Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого:** Орхонтуул, Орхон зэрэг сумдын ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах хадлангийн талбайн орлого нийт 71.6 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Төлөвлөгөө тасарсан орлого:

- **Малын тоо толгойн албан татварын орлого:** Цагааннуур, Сайхан, Орхонтуул сумд нь малын тоо толгойн албан татварыг хэт өндөр төлөвлөснөөс 337.0 сая төгрөг, Зүүнбүрэн, Түшиг, Сант сумд нь удаан хугацаанд татварын байцаагчгүй ажиллаж, малчин болон мал бүхий иргэдийн татварыг бүрэн төлүүлээгүйгээс 121.3 сая төгрөг дутуу төвлөрүүлж, нийт 614.7 сая төгрөгөөр,
- **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Сүхбаатар, Хүдэр, Ерөө, Алтанбулаг зэрэг сумд нь хураамжийг төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүйгээс хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нийт 32.5 сая төгрөгөөр тасалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын данстай холбоотой нийт **145.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
Үүнд:

- Баруунбүрэн сум 10.6 сая төгрөг, Жавхлант сум 12.8 сая төгрөг, Зүүнбүрэн сум 80.1 сая төгрөг зэрэг нийт **103.5** сая төгрөгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасалсан,
- Зүүнбүрэн сумын ЗДТГ 2.4 сая төгрөг, Шаамар сумын ЗДТГ 8.1 сая төгрөг, Дулаанхан тосгоны захирагчийн алба 9.7 сая төгрөг, аймгийн ОНӨГ 7.1 сая төгрөг зэрэг нийт **27.3** сая төгрөгийн төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг холбогдох шийдвэргүйгээр зарцуулсан,

- *Буянт тосгоны Захирагчийн алба нь 14.4 сая төгрөгийн хандивын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж, баяр наадмын зардалд зарцуулсан.*

3.4.10 Зардлын данс

Зардлын данстай холбоотой нийт **601.5** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

1. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн, бие даан дүгнэлт гаргалгүйгээр түүвэрт хамрагдсан байгууллагуудад зардлын данстай холбоотой дараах **1.8** сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- *Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос аймгийн ОНӨГ-ын албан хаагчдыг томилолтоор ажиллах хугацаанд байрны зардлыг 1.4 сая төгрөг, Энх мэнд сувилал ААТҮГ нь 4 ажилтанд 0.4 сая төгрөгийн цалин зэрэг нийт 1.8 сая төгрөгийг илүү тооцож, олгосон.*

2. Бие даасан дүгнэлт гарсан төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч, ОНӨААТҮГ-т дараах **599.7** сая төгрөгийн зөрчил илэрлээ. /Хавсралт №2-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- *Цалин, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжийг 19 байгууллага зөрүүтэй тооцож нийт 28.9 сая төгрөг олгосон,*
- *Албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийг 5 байгууллага 12.3 сая төгрөгөөр давхардуулан олгосон,*
- *21 байгууллага 207.2 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,*
- *24 байгууллага нийт 256.5 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,*
- *Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ нь махны нөөц үүсгэх зориулалтаар өмнөх онуудад аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын 53.0 сая төгрөгийг татварын өрөнд суутгуулснаас 2023 онд махны нөөц бүрдүүлээгүй,*
- *Мандал сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүйгээр 29.4 сая төгрөгийн тэтгэмж, танилцуулга, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн,*
- *Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ нь бусдад 1.5 сая төгрөгийн хандив өгсөн,*
- *Шаамар сумын хөрөнгө оруулалтаар зах зээлийн үнээс 10.9 сая төгрөгөөр өндөр үнээр хөрөнгө бэлтгэсэн.*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2023 оны төсвийн орлого, зарлагыг тус бүр **52,026.2** сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Орлого:

- *Орон нутгийн суурь орлогыг 24,337.0 сая төгрөгөөр,*
- *ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 16,630.7 сая төгрөгөөр,*
- *Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 6,303.5 сая төгрөгөөр,*
- *Урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 1,655.0 сая төгрөгөөр,*
- *Аж ахуйн нэгжийн хандиваас төвлөрүүлэх орлогыг 3,100.0 сая төгрөгөөр,*

Зарлага:

- *Төсвийн урсгал зардлыг 12,656.5 сая төгрөгөөр,*
- *ОНХО-ыг 26,646.2 сая төгрөгөөр,*
- *Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 8,405.1 сая төгрөгөөр,*
- *Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,318.4 сая төгрөгөөр гэх мэт.*

Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар “Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулан Сэлэнгэ аймгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 980.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **5,298.4** сая төгрөгөөр, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 3,698.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, **20,328.8** сая төгрөгөөр баталсныг үндэслэн аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2023 оны төсвийн нийт орлого, зарлагыг тус бүр **7,362.5** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **59,388.7** сая төгрөгөөр баталсан байна.

Орлого талд:

- *Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 3,698.1 сая төгрөг,*
- *Нэр заагдаж ангилагдаагүй орлогыг 25.0 сая төгрөг,*
- *Сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогыг 192.3 сая төгрөг,*
- *Урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 4,196.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,*
- *Сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогыг 192.3 сая төгрөг,*
- *Хандивын эх үүсвэрийг 364.8 сая төгрөгөөр бууруулахаар,*

Зарлага талд:

- *Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 980.0 сая төгрөгөөр,*
- *ОНХО-ын зардлыг 3,877.3 сая төгрөгөөр,*
- *Аймгийн төсвийн урсгал зардлыг 1,008.4 сая төгрөгөөр,*
- *Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 1,496.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,*

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг хийж, аймгийн 2023 оны төсвийн нийт орлого,

зарлагыг тус бүр **300.0** сая төгрөгөөр нэмэгдүүлж, **59,688.7** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Орлого талд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2,200.0 сая төгрөгөөр бууруулж,
- Сумын төсвөөс аймагт төвлөрүүлэх орлогыг 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр,

Зарлага талд:

- Аймгийн ЗДНХ-ийн зардлыг **300.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр.

Сумдын 2023 оны төсвийн нийт орлогыг 29,065.1 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,550.4 сая төгрөгөөр /ХХС орсон/, туслах үйл ажиллагааны орлогыг 15.7 сая төгрөгөөр, хандивын эх үүсвэрийг 1,536.1 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлийг 16,759.6 сая төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **48,926.9** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Ингэснээр Сэлэнгэ аймгийн нийт орлого, зарлагыг тус бүр **108,615.6** сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 30 хөтөлбөрийн 51 арга хэмжээг санхүүжүүлэхээр **108,615.6** сая төгрөгийн төсөв батлагдсанаас 60,447.3 сая төгрөгийг урсгал зардалд, 45,271.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 2,897.1 сая төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 59,838.1 сая төгрөгийг татварын ба татварын бус орлогоос, 20,282.0 сая төгрөгийг ОНХС-ийн шилжүүлгээс, 1,471.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, 15.6 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 22,611.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 4,271.3 сая төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивын орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/сая төгрөгөөр/

Код	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1300	Аймаг	38,834.7	33,054.2	5,780.6	85.1
1301	Алтанбулаг	2,139.5	1,941.6	197.9	90.7
1302	Ерөө	9,246.1	6,514.6	2,731.5	70.5
1303	Зүүнбүрэн	2,148.2	1,527.4	620.8	71.1
1304	Мандал	12,053.0	10,670.6	1,382.4	88.5
1305	Орхон	1,955.8	1,825.0	130.8	93.3
1306	Сант	1,758.5	1,465.3	293.2	83.3
1307	Цагааннуур	3,064.2	2,366.8	697.4	77.2
1308	Баянгол	2,984.0	2,812.1	171.9	94.2
1309	Сайхан	6,505.9	5,331.6	1,174.3	81.9
1310	Орхонтуул	2,971.3	2,119.2	852.1	71.3
1311	Баруунбүрэн	2,839.9	2,415.9	424.0	85.1
1312	Шаамар	2,889.2	2,496.0	393.2	86.4

1313	Хүдэр	4,658.9	4,165.5	493.4	89.4
1314	Сүхбаатар	8,992.3	8,317.1	675.2	92.5
1315	Жавхлант	1,840.8	1,493.1	347.8	81.1
1316	Түшиг	2,009.7	1,537.8	471.9	76.5
1317	Хушаат	1,723.4	1,558.2	165.1	90.4
	Нийт	108,615.6	91,612.1	17,003.4	84.3

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр 69,591.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, ОНХС-аас 20,170.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 1,827.5 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 59.0 сая төгрөг, нийгмийн хариуцлагын хүрээнд ААНБ-аас өгсөн хандивын орлогоос 30.0 сая төгрөг зэрэг нийт **91,678.6** сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 91,612.1 сая төгрөг буюу 84.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 3,970.3 сая төгрөгөөр хэмнэж, хөрөнгийн зардал 11,898.2 сая төгрөгөөр, ХХС-ийн эргэж төлөгдөх зээл 1,135.0 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдсэнээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал нийт 3,970.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 851.8 сая төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 942.1 сая төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 113.3 сая төгрөгөөр,
- Нормативт зардал 10.9 сая төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 153.4 сая төгрөгөөр,
- Томилолтын зардал 31.5 сая төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 537.2 сая төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 882.5 сая төгрөгөөр,
- Урсгал шилжүүлэг 447.6 сая төгрөгөөр зэрэг.

Тайлант онд аймгийн ОНХО, ОНХС, Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд 45,271.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 33,373.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, хандив тусламжийн эх үүсвэр бүрдээгүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгараагүй зэрэг шалтгааны улмаас хөрөнгийн зардал 11,898.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

ХХС-аас 2,897.1 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,762.1 сая төгрөгийн зээл олгож, эргэж төлөгдөх зээлийг 1135.0 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗДНХ-өөс 1,723.4 сая төгрөг, хандиваар 337.2 сая төгрөг, бусад төсвийн захирагчаас 2,627.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,086.3 сая төгрөг зэрэг нийт 5,774.7 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, дараах зардлуудад 5,156.5 сая төгрөгийг зарцуулж, 618.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгоогчийн НДШ-ийн зардалд 26.8 сая төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 12.2 сая төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 86.9 сая төгрөг,
- Нормативт зардалд 16.9 сая төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 283.4 сая төгрөг,
- Томилолт, зочны зардалд 9.3 сая төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 90.1 сая төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 3,334.2 сая төгрөг,
- Урсгал шилжүүлэгт 492.5 сая төгрөг,
- Хөрөнгийн зардалд 804.2 сая төгрөг зэрэг нийт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 15,779.3 сая төгрөгийн 95 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 7,068.6 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ,
- Аймгийн ОНХО-ын хөрөнгөөр 6,195.7 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээ,
- Замын сангийн хөрөнгөөр 320.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
- БХНСАХЗ-аар 1,400.5 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ,
- Хандив, зээл тусламжийн хөрөнгөөр 680.2 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
- Аймгийн ЗДНХ-өөр 114.3 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ.

Худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас гүйцэтгэлээр зөвлөх үйлчилгээ 1, шууд худалдан авах 1, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 31, нээлттэй тендер шалгаруулах 51, нийт 84 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 13. Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан:

/сая төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс								
			Зөвлөх үйлчилгээ		ШХА		Харьцуулалтын арга		НТШ		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

Аймгийн ОНХС	32	6,795					8	535.2	24	6,260.1
Аймгийн ОНХО	40	4,979	1	100.0	1	10.0	17	1,060.5	21	3,808.2
Замын сан	1	320							1	320.0
БХНСАХЗ	10	1,401					6	386.3	4	1,014.3
Хандив, зээл тусламжийн хөрөнгөөр	1	680							1	680.2
Дүн	84	14,174.6	1	100.0	1	10.0	31	1,981.9	51	12,082.7

Эх сурвалж: tender.gov.mn

Харин дараах 1,604.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь оролцогч ирээгүйгээс хүчингүй болсон болон зураг, төсөв нь хийгдээгүйгээс зарлагдаагүй байна. Үүнд:

- *Захиалагч байгууллагаас 907.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний төсөв, техникийн тодорхойлолт, холбогдох материалыг аймгийн ОНӨГ-т ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зарлаагүй,*
- *697.7 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг тус бүр 2-10 удаа зарласан боловч оролцогч ирээгүй шалтгаанаар хүчингүй болсон.*

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн авлага, өр төлбөрийн барагдуулалт, санхүүгийн тайлангийн нэгтгэл, дотоод аудит, хяналт шалгалт болон анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор, Ц.Отгонбаяр, аудитор О.Анхбаяр, Б.Наранцэцэг нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/390 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 61,897.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 928.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу **696.3** сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 84,080.9 сая төгрөгийн 1.5 хувь буюу 1,261.2 сая төгрөгийн 75 хувиар тооцон, **945.9** сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчтай хамааралтай дараах заалтуудыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- *Аймгийн Засаг дарга нэг орлогч даргатай ажилласан,*
- *Аймгийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглаагүй,*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй,*
- *Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулаагүй,*
- *Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй байна.*
- *Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж буй авто машинуудад цэнхэр дэвсгэр бүхий дугаар авсан гэх мэт.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

- *Аймгийн ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 155 мэдээллээс 106 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 9 төрлийн 49 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,*
- *Илдэнбүрэн ААТҮГ нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 13 мэдээллийг хугацаа хоцроосон,*
- *Энх мэнд сувилал ААТҮГ нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,*
- *Баянгол сувилал ААТҮГ нь шилэн дансны цахим системд цэс нээлгээгүй, мэдээлбэл зохих мэдээллийг байршуулаагүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Илдэнбүрэн ААТҮГ, Энх мэнд сувилал ААТҮГ-т Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Илдэнбүрэн ААТҮГ нь нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”*-ийн 2: *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

2. “Баянгол сувилал” ААТҮГ, Мандах Зэлтэр тохижилт үйлчилгээ” ААТҮГ нь 2023 оны “Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө” боловсруулж, сумын ИТХ-аар батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх *“Захирал дараах эрх, үүрэгтэй: 3/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”*, Баянгол сумын ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан *“Баянгол сувилал орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм”*-ийн 9.5 дахь *“Тухайн жилийн төсвийг өмнөх оны 12 дугаар сарын 20-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, тайлагналтыг дараа оны эхний хагас жилд иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 121 дүгээр “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд аймгийн ТЕЗ-ийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 12.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 180.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 58.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 14. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	12.1	2	12.1	100
Албан шаардлага	3	180.0	3	180.0	100
Зөвлөмж	15	58.8	15	58.8	100
Нийт дүн	20	250.9	20	250.9	100

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас аймгийн ОНХС, ОНХО-ын төсөл, арга хэмжээний зөвхөн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулж, зөрчлийг “Сэлэнгэ аймгийн 2023 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл”-д хийсэн аудитад тусгасан.

Харин худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт 121,268.9 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 121,263.3 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 5.6 сая төгрөгийн алдааг арилгах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт **121,263.3** сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд нийт хөрөнгийг 4,188.6 сая төгрөгөөр илүү,
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлогыг 7,003.6 сая төгрөгөөр дутуу, үйл ажиллагааны зардлыг 30,505.7 сая төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны орлогыг 38,423.5 сая төгрөгөөр илүү, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 41,141.9 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

1. Илдэнбүрэн ААТҮГ нь тайлант онд үйлдвэрлэсэн боловч ашиглаагүй **5.6** сая төгрөгийн блокийг бараа материалын үлдэгдлээр бус шууд зардалд тайлагнасан.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын үлдэгдлийг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгөв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, 87 төсвийн байгууллага, 25 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж зэрэг нийт 129 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан 129 санхүүгийн тайлангаас төсөв, санхүүжилт, хамрах хүрээ, аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөө харьцангуй багатай 95 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 34 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт хүргүүлжээ. Үүнд:

- 21 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”,
- 13 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн болно.

Хүснэгт 15. Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байгууллагууд:

№	Байгууллагын нэрс	№	Байгууллагын нэрс
1	Баруунбүрэн сумын ТТЗ	8	Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ
2	Жавхлант сумын ТТЗ	9	Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ
3	Зүүнбүрэн сумын ТТЗ	10	Сэлэнгэ Энержо ОНӨААТҮГ
4	Түшиг сумын ТТЗ	11	Сэлэнгэ Цэнгэг Ус ОНӨААТҮГ
5	Хушаат сумын ТТЗ	12	Туулын хишиг ОНӨААТҮГ

6	Шаамар сумын ТТЗ	13	Гавшгай ус ОНӨААТҮГ
7	Аймгийн ИТХ		

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын Санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэл

Аймгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит:

Аудитаар нийт **133,191.8** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **128,305.3** сая төгрөгийн алдааг залруулж, **75.6** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **3,445.4** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **18** албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, **1,365.5** сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **548.1** сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **204.0** сая төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж хүргүүлсэн байна.

Үүнээс:

1. Бие даасан дүгнэлт өгсөн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар:

ТЕЗ-ийн харьяа 4 шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргаснаас 3 санхүүгийн тайланд тус тус “Өөрчлөлтгүй”, аймгийн ИТХ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **532.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **294.7** сая төгрөгийн алдааг залруулж, **9.8** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **103.7** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **124.4** сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **88.0** сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 17 сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргаснаас 11 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй”, Баруунбүрэн, Жавхлант, Зүүнбүрэн, Түшиг, Хушаат, Шаамар зэрэг 6 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **4,153.5** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **2,594.6** сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, **37.0** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, **634.0** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага,

12 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **887.9** сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **341.7** сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **101.8** сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлсэн байна.

3. Бие даасан дүгнэлт өгсөн ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж, бие даасан дүгнэлт өгсөн 13 ААТҮГ-аас 7 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 6 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **7,203.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **4,152.7** сая төгрөгийн алдааг залруулж, **27.0** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **2,700.7** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, **322.7** сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **118.4** сая төгрөгийн 5 албан шаардлага, **102.2** сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлсэн байна.

4. Аймгийн ТЕЗ-ийн түвшний санхүүгийн тайлангийн аудитаар:

Аймгийн ТЕЗ-ийн түвшний санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт **33.7** сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс **1.8** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, **7.1** сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 4 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах санал, **24.8** сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **802.4** сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **143.5** сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт:

1. ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн боловч бие даан дүгнэлт гаргалгүйгээр түүвэрт хамрагдсан дараах байгууллагууд бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос **1.8** сая төгрөгийг илүү олгосон дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- *Аймгийн ОНӨГ нь албан хаагчдыг томилолтоор ажиллах хугацаанд байрны зардлыг 1.4 сая төгрөгөөр илүү тооцож олгосон,*
- *Энх мэнд сувилал ААТҮГ нь 4 ажилтанд 0.4 сая төгрөгийн цалин илүү тооцож олгосон байна.*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог

хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, олговрыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Аймгийн ОНӨГ нь төлөвлөгөөнөөс давсан 7.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулахаар эрх олгосон боловч БНХАУ-д аялах аяллын зардалд шилжүүлэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, аймгийн Засаг даргын 2023 оны А/636 дугаар захирамжийн “... нэмэлт орлогын давж биелсэн орлогын дүнгээр төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, “Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө” боловсруулж, сумын ИТХ-аар батлуулаагүй, төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан зэрэг зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн Э.Ганчимэг, Жавхланта сумын Засаг дарга Дарханбаатар, Баянгол сувилал ААТҮГ-ын дарга Х.Отгонцэцэг, Мандах Зэлтэр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын дарга М.Батсайхан нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөрийн барагдуулалттай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Авлага, өр төлбөр дансанд бүртгэлтэй олон жилийн насжилттай эзэн холбогдогч нь тодорхой бус, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, оршин суугаа хаяг тодорхой бус байдлаас болж шүүхэд хандах боломжгүй болон хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх мэт авлага, өр төлбөрийг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг

гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид насжилт өндөртэй авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол холбогдох байгууллагад уламжилж, данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлэх.

2. Санхүүгийн тайлангийн нэгтгэлтэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Сумдын ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан ААТҮГ-уудын санхүүгийн тайланг сумдын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэлгүйгээр аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэн, тайлагнаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумдын ИТХ-ын шийдвэрээр байгуулагдсан ААТҮГ-уудын санхүүгийн тайланг сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байх.

3. Дотоод аудит, хяналт шалгалттай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа, хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Сангийн сайдын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ТЕЗ-ийн дотоод хяналт шалгалт, аудитын үр нөлөөг сайжруулах замаар төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд оршин буй алдаа зөрчлийг арилгах.

4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Илдэнбүрэн ААТҮГ нь аж ахуйн нэгж байгууллагуудтай тухай бүр гэрээ байгуулан нүүрс, шатахуун, цемент, бичиг хэрэг, барилгын засварын материалыг худалдан авч, зарцуулсан боловч жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “ ...

бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулж байх.

2. Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

Энх мэнд сувилал ААТҮГ:

- *Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулаагүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй,*
- *Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийн тайлан гаргаагүй буюу хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтагүй,*
- *Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5.1 сая төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.*

Хүдэр тохижилт ОНӨААТҮГ:

- *Анхан шатны бүрдэл дутуу баримтаар “Нийтийн эзэмшлийн хур хог хаягдлыг зайлуулах” төсөл, арга хэмжээний 19.7 сая төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.*

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1: “*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;*” 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20.2.6 дахь “ *... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.*

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	3	121,263.3			3	121,263.3	3	121,263.3				
Илдэнбүрэн ААТҮГ	1	5.6			1	5.6			1	5.6	1	5.6
Дүн	4	121,268.9			4	121,268.9	3	121,263.3	1	5.6	1	5.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ТЕЗ	4						3	-	1	4		
Аймгийн ОНӨГ	2	8.4	1	1.4	1	7.1						
Илдэнбүрэн ААТҮГ	1	-		-			1	-				
Энхмэнд сувилал ААТҮГ	2	5.5	1	0.4		-	1	5.1				
Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	1	19.7		-			1	19.7				
Дүн	10	33.7	2	1.8	1	7.1	6	24.8	1	4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс
------------------	-------------	--------

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Илдэнбүрэн ААТҮГ	1	-					1	-
Энх мэнд сувилал ААТҮГ	1	-					1	-
Дүн	2	-					2	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Илдэнбүрэн ААТҮГ	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	3	-			1	-	2	-

Авлага, өр төлбөрийн данстай холбоотой зөрчлийн нэгтгэл

4317143998

/сая төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Зөрчлийн утга			Нийт зөрчлийн дүн
		Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс авлага үүсгэсэн.	Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн.	Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгалгүйгээр тайлант оны төсвөөс төлж барагдуулсан.	
1	Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	0.6			0.6
2	Сант сумын ЗДТГ	4.2			4.2
3	Сүхбаатар сумын Засаг дарга	13.9			13.9
4	Түшиг сумын ИТХ	0.4			0.4
5	Түшиг сумын ЗДТГ	0.1			0.1
6	Хүдэр сумын ИТХ	2.5			2.5
7	Хүдэр сумын ЗДТГ	1.8			1.8
8	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	0.3			0.3
9	Ерөө сумын Сумын ИТХ		4.5		4.5
10	Жавхлант сумын ИТХ		0.2		0.2
11	Жавхлант сумын ЗДТГ		0.8		0.8
12	Орхон сумын ЗДТГ		2.7		2.7
13	Орхонтуул сумын ИТХ		0.6		0.6
14	Сайхан сумын Орон нутгийн хөгжлийн сан		4.2		4.2
15	Мандал сумын ЗДТГ			13.2	13.2
16	Шаамар сумын ЗДТГ			0.4	0.4
	Нийт дүн	23.7	12.8	13.6	50.2

40	Түшиг сумын Орон нутгийн хөгжлийн сан			7.3		7.3
41	Хушаат сумын ЗДТГ	1.7		33.8	8.7	44.3
42	Хушаат сумын ИТХ	1.6			5.1	6.7
43	Хүдэр сумын ЗДТГ			6.0		6.0
44	Хүдэр сумын ИТХ			24.3		24.3
45	Цагааннуур сумын ЗДТГ	6.7			1.9	8.6
46	Шаамар сумын ЗДТГ	2.0			5.8	7.8
	Нийт дүн	28.9	12.3	207.2	256.5	505.0

**Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллагаар
тооцсон зөрчлийн нэгтгэл**

д/д	Данс	Аудитын илрүүлэлт	/сая төгрөг/ Мөнгөн дүн
1	Авлага	Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 8 байгууллага авлага үүсгэсэн.	23.7
2	Өр төлбөр	Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 7 байгууллага өр төлбөр үүсгэсэн.	12.8
3		Шаамар сумын ЗДТГ, Мандал сумын ЗДТГ нь өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй өр төлбөрийг тайлант оны төсвөөс төлж барагдуулсан.	13.6
4	Орлогын данс	Баруунбүрэн сум 10.6 сая төгрөг, Жавхлант сум 12.8 сая төгрөг, Зүүнбүрэн сум 80.1 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасалсан.	103.5
5		Зүүнбүрэн сумын ЗДТГ 2.4 сая төгрөг, Шаамар сумын ЗДТГ 8.1 сая төгрөг, Дулаанхан тосгоны захирагчийн алба 9.7 сая төгрөг, аймгийн ОНӨГ 7.0 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг холбогдох шийдвэргүй болон зориулалт бусаар зарцуулсан.	27.3
6		Бугант тосгоны Захирагчийн алба нь хандивын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж, баяр наадмын зардалд зарцуулсан.	14.4
7	Зардлын данс	Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос аймгийн ОНӨГ-ын албан хаагчдыг томиллоор ажиллах хугацаанд байрны зардлыг 1.4 сая төгрөг, Энх мэнд сувилал ААТҮГ нь 4 ажилтанд 0.4 сая төгрөгийн цалин илүү тооцож, олгосон.	1.8
8		Цалин, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжийг 19 байгууллага зөрүүтэй тооцож олгосон.	28.9
9		Албан томиллоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийг 5 байгууллага давхардуулан олгосон.	12.3
10		21 байгууллага анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	207.2
11		24 байгууллага батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	256.5
12		Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ААТҮГ нь махны нөөц үүсгэх зориулалтаар өмнөх онуудад аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын 53.0 сая төгрөгийг татварын өрөнд суутгуулснаас 2023 онд махны нөөц бүрдүүлээгүй.	53.0
13		Мандал сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэлгүйгээр тэтгэмж, танилцуулга, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн.	29.4
14		Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ нь хандив өгсөн.	1.5
15	Шаамар сумын хөрөнгө оруулалтаар зах зээлээс өндөр үнээр хөрөнгө бэлтгэсэн.	10.9	
		Дүн	796.8



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2024.04.17 № 01/437

танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой санал, тайлбаргүй бөгөөд аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах болно.



Н.ЛХАГВАДОРЖ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 19 өдөр


Дугаар 05

Сүхбаатар сум

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн ИТХ-ын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж) нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж)-д зөвлөсүгэй
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Т.Болор)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.04.19 № 15
танай _____-ны № _____-т

«САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан болон хавсралт судалгааг гаргаж хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА